



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СУРГУУЛЬ



ОЛОН УЛСЫН
ХАРИЛЦАА

WORLD AFFAIRS

Олон улсын
харилцаа
ны
сурвалж

2010 №2 362 (21)



УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СУРГУУЛЬ



ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

WORLD AFFAIRS

2010 №2 362 (21)



Улаанбаатар хот

DDC
327.015
O-295

Тус сэтгүүл нь анх 1996 оноос “Алтан аргамж” нэрээр, 2002 оноос “Олон улсын харилцаа” нэрээр гарч байна.

The journal has been published since 1996 as “Altan argamj” and since 2002 as “World Affairs”

Сэтгүүлийн зөвлөл:

Эрхлэгч:

Н.Алтанцэцэг (Проф., Ph.D)

Нарийн бичгийн дарга:

Д.Тунгалаг (Проф., Ph.D)

Гишүүд:

Ж.Баясах (Проф., Sc.D)
Д.Отгончимэг (Проф., Ph.D)
Б.Энхбаяр (Проф., Ph.D)
Д.Цолмон (Проф., Ph.D)
Д.Намсрай (Проф., Ph.D)
Ж.Баттогтох (Дэд проф., Ph.D)

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

С.Оюунсүрэн (Ph.D)

Сэтгүүлийн хаяг:

МУИС-ийн Олон улсын харилцааны сургууль
Шуудангийн салбар - 46 а, хайрцаг - 6
Улаанбаатар, Монгол улс
Утас: 354610;354611;354618
Факс: (976-11) 354610
E-mail: muis_sfs@yahoo.com

Editorial Board:

Editor in Chief:

N.Altantsetseg (Prof., Ph.D)

Assistant Editor

D. Tungalag (Prof., Ph.D)

Members:

J.Bayasakh (Prof., Sc.D)
D.Otgonchimeg (Prof., Ph.D)
B.Enkhbayar (Prof., Ph.D)
D.Tsolmon (Prof., Ph.D)
D.Namsrai (Prof., Ph.D)
J.Battogtokh (Prof., Ph.D)

Publishing design:

S.Oyunsuren (Ph.D)

Editorial Address:

School of Foreign Service
National University of Mongolia
P.O.-46 a, Box-6
Ulaanbaatar, Mongolia
Tel:354610; 354611;354618
Fax: (976-11) 354610
E-mail: muis_sfs@yahoo.com

ISBN 978 99962 53 60 7

ГАРЧИГ

I. Олон улсын харилцаа, Монгол улсын гадаад бодлого, түүх

Олон улсын харилцааны онол – улс төрийн идеализм	3
<i>Д. Долгорсүрэн</i>	
Монгол улс-Европын холбоо: иж бүрэн түншлэл өөд	15
<i>Д. Уламбаяр</i>	
Монголын эзэнт гүрэн ба “Их Юань”	37
<i>Ким Ходон</i>	
Мин улсын гадаад бодлого ба алтан хантай харилцсан дипломат баримт бичгийн тухайд.....	57
<i>Д. Ундрах</i>	

II. Олон улсын эрх зүй

Хүрээлэн буй орчны эрх зүйн салбар дахь олон улсын хамтын ажиллагаа	69
<i>Д. Бадамцэцэг</i>	
Хүний аюулгүй байдлын асуудалд жендэрийн тэгш байдлыг тусгах нь	74
<i>Э. Өлзийлхам</i>	

III. Олон улсын эдийн засгийн харилцаа

Монгол улс, БНХАУ-ын эдийн засгийн харилцаа	85
<i>А. Батцэцэг</i>	
Гадаад худалдааны бодлогын зарим асуудалд.....	90
<i>П. Лхамсүрэн</i>	
Дэлхийн хөгжлийн хандлага: хөгжиж буй орнуудын нөлөө, жин.....	94
<i>Б. Санжмятав</i>	
Мянганы хөгжлийн нэн тэргүүн зорилт болох ядууралтай хэрхэн тэмцэж байна вэ?	100
<i>Л. Цэцгээ</i>	

IV. Хэл шинжлэл

Өвөр Монголын орчуулгын үйлсийн хөгжлийн тухай өгүүлэх нь	105
<i>Н. Улаан-Од</i>	

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ОНОЛ – УЛС ТӨРИЙН ИДЕАЛИЗМ

Д. Долгорсүрэн¹

Олон улсын харилцааны мэргэжлээр мэргэшиж зэрэг хамгаалахаар суралцаж буй докторант хүний хувьд миний бие олон улсын харилцааны онолын судалгаанд төдийгүй улс төрийн шинжлэх ухаанд “идеа, идеализм” хэмээх нэр томъёог юуны учир чухалчлан авч үздэгийг мөн яагаад энэ нэр томъёог эрдэмтэн судлаачид хэрэглэсээр ирснийг, тэр дундаа олон суут мэргэд өөрсдөө идеалист үзэлтэй байсны учрыг хамгийн гол нь идеалист үзэл баримтлал гэгч оршин буйн учир шалтгаан чухам юунд болохыг сонирхон судалж үзсэн юм.

Идеа буюу *идеализм* хэмээх үгсийн уг гарвалыг хөөвөл *санаа бодол* ба *санаа бодол бол анхдагч хэмээх үзэл* гэсэн утгыг илэрхийлдэг аж. Өөрөөр хэлбэл орчлон хорвоо, олон улс гүрэн, хүн төрөлхтөн үүсээгүй байхад тэр санаа бодол буюу хүчит оюун ухаан оршин байсан бөгөөд тэр л хамгийн анхдагч нь байжээ гэж үүнийг тайлбарлаж болохоор байна. *Идеализм* гэдэг үгийг *туйлын зорилгодоо үнэнч байх, хэт бодитой бусаар сэтгэх* гэх зэргээр толь бичигт тайлбарласан байх юм. Аливаа хүнд олон зорилго байх нь мэдээж, харин нийт хүн төрөлхтөний туйлын зорилго гэдэг чухам юу вэ? Хүн төрөлхтөн юуг хүсч, юунд тэмүүлдэг юм бэ? Хүмүүс амар тайван, жаргалтай амьдрахыг хүсдэг. Үхэл хагацалгүй, буруутгал шийтгэлгүй, баяр хөөр, хайр дүүрэн амьдралыг л үнэндээ бүгд хүсдэг. Хүмүүс өөрсдийнхөө итгэсэнчлэн, мөн дээд эрх мэдэлтнүүдийн ялган заагласнаар өөр өөр нутаг дэвсгэр, хил хязгаар дотор хуваагдан, харьяалагдан амьдардаг болохоос бус, Хятад, Монгол, Орос, Америк, Африк, Араб, Испани болон бусад үндэстэн ястнуудад хүн болохынх нь хувьд ялгаа байдаггүй. Бүгд л адилхан хүсэл тэмүүлэлтэй, амь амьдрал, өвчин зовлон, гуниг гутралыг мэдэрдэг агаад сайн сайхан, баяр жаргалтай, дайн дажингүй элэг бүтэн амьдрахыг хүсдэг.

Хүмүүс өөрсдийнхөө итгэж баримталдаг хийсвэр зүйл болох нийгмийн ялгаа буюу зэрэг дэв, эрдэм боловсрол, эд баялаг, эзэмшсэн мэргэжил зэргээрээ ялгагдахаас бусдаар нийт хүн төрөлхтөн бүгд ижил билээ. Тийм ч учраас *бүгд нүцгэн төрөөд нүцгэн буцдаг* гэж яруу найрагчид шүлэглэдэг. Төрсний дараа үхэх нь зайлшгүй гэж ярьдаг ч үнэндээ үхэх дуртай, үхэхийг зөвшөөрдөг хүн маш цөөн. Тэгвэл дайн дажин, нийгмийн ялгаварлал, үхэл сүйрэл зайлшгүй гэж үздэг хүмүүсийн хувьд “*нийт хүн төрөлхтөн сайн сайханд хүрч болно, дайныг бүх нийтээр хориглон зогсоож болно, дэлхийн сүйрлийг хойшлуулж, дэлхий дээр бүгдийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагыг бий болгож болно*” хэмээн үздэг идеалистүүдийн санаа бодол нь хоосон мөрөөдөл бөгөөд тэд идеалистүүдийг шүүмжилж, хэт

¹ МУИС-ийн ГХСТ – ийн ахлах багш, ОУХС-ийн докторант

бодитой бусаар сэтгэж байна, хэзээ ч бүтэшгүй зүйл хэмээн мохоосоор иржээ. Идеализмыг баримтлагчдыг хоосон мөрөөдөгчид, үл гүйцэлдэх санаатнууд хэмээн нэрлэсээр ирсэн хэдий ч үнэн хэрэг дээрээ, идеалистүүдийн хэлж бичиж ирсэн зүйл нь хэрэв биелэх юм бол загатнасан газар маажсан мэт болгох хамгийн гол, чухал зүйлүүд байдаг.

Германы сонгодог философийн нэрт төлөөлөгч болох **Георг Вильгельм Фридрих Гегель** нь объектив идеалист үзэлтэн байсан бөгөөд тэрээр байгаль нийгмийн үүсэл хөгжлийн анхдагч шалтгаан нь биегүй оюун ухаан буюу ертөнцийн санаа юм гэж үздэг байжээ. Тэгвэл тэрхүү ертөнцийн санаа буюу оюун ухаан гэдэг нь чухам юу вэ, эсвэл хэн бэ гэсэн асуулт аяндаа урган гарах юм. Тэр **хүчит санаа бодол** буюу **оюун ухааныг** таньж мэдэхийн тулд л хүн төрөлхтөн янз бүрийн арга хэрэглэсээр, төрөл бүрийн шашин, үзэл, онолуудыг боловсруулан зохиосор, сүүлдээ өөрсдийнхөө зохиосон зүйлд итгэж, дагаж баримталсаар ирсэн бололтой. Үнэхээр тийм санаа, **бүтээгч санаа** анх оршин байж, тэр нь байгаль, нийгэм болон түүн дээр оршигч олон улс орнууд, хүн төрөлхтөнийг бий болгосон гэж эрт үед олон эрдэмтэн мэргэд итгэдэг байсан ба тэр итгэл нь дамжсаар байжээ. Ийм учраас **идеализм** буюу **оюун санаа анхдагч** гэсэн энэ үзэл олон мянган жил оршин байсаар, судлаач эрдэмтдийн үг яриа, зохиол бүтээлээс хасагдалгүй явсаар өнөөгийн бидэнд өвлөгдөн хүрч иржээ.

Идеалистүүдийг “хоосон мөрөөдөгчид” гэдэг ч чухамдаа тэдний ярьж мөрөөдөж байдаг зүйлд л хүрэх гэж хүн төрөлхтөн хичээсээр ирсэн нь түүхэн үнэн билээ. Харин хичээгээд байхад тэдгээр нь үл гүйцэлдэх зүйлс байгаад байдгийн учир шалтгаан нь юу вэ? Яагаад хүн төрөлхтөн эх дэлхий дээрээ дайн дажингүй байж чадахгүй байна, олон улс гүрнүүд юуны учир өөр хоорондоо эв түнжингүй байсаар ирэв? Үүний гол шалтгаан нь ямар нэгэн амьтан, ургамал юм уу эсвэл газар нутаг, далай тэнгис биш харин хүн өөрөө аж. Тухайлбал хүний буруутай үйл ажиллагаа, хорон муу санаа, шунахай атаач зан, хатуу сэтгэл, ханадаггүй, талархдаггүй, бардам сэхүүн байдал л эрт үед дайн тулаанд хүргэж, эдүгээ үед үл ойлголцол, эрх мэдэл, эд баялаг болон хүчний төлөөх тэмцэлд хүргэсээр байна.

Олон улсын харилцааны онол болон улс төрийн шинжлэх ухааны судлах гол зүйл нь хүний нийгэм билээ. Тэгвэл хүний нийгмийг судлахын тулд хүнийг судлах хэрэгтэй гэсэн үг. Хүний мөн чанар ямар байгааг, хичнээн муу муухайг хийгээд бодоод байгааг нь биш, харин ямар байх ёстойг нь, яавал хүсэхгүй байгаа муугаасаа илүү хүсээд байдаг зөв сайн зүйлийг хийдэг, боддог болгох боломж арга замыг судалж мэдээд, хүн төрөлхтөнд хэлж зааж, чиглүүлж өгөх нь эрдэмтэн мэргэд, багш судлаачдын үүрэг болов уу. Онол практикаар шалгагддаг гэдэг. Тэгвэл идеализмын онол нь эрт үеэс шалгагдсаар тэсч үлдээд, техник технологи өндөр хөгжсөн эдүгээ цагт ч хүчтэй онолын нэг хэвээр байна.

Хүний мөн чанарт буй элементүүд улс оронд байдаг гэдэг тул хүний мөн чанарыг зөв сайн болговол улс орны мөн чанар ч өөрчлөгддөг нь идеалист үзэл баримтлалтай улс орнуудад ажиглагддаг. АНУ, Франц, Герман, Англи, Канад, Япон, Өмнөд Солонгос зэрэг дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад ихэнх хүмүүс нь идеалист сэтгэлгээтэй байдаг гэж уншиж байсан санагдана. Идеалист сэтгэлгээ нь хийсвэр зүйлийг хүлээн авахад ямар ч асуудалгүй байдаг тул тийм сэтгэлгээтэй улс орны хүмүүс нь дүрэм журамд захирагдан, жинхэнэ үнэн зөв гэсэн үзэл бодол, үнэнийг итгэн дагаж, олон ургальч үзэл бодлыг хүлээн зөвшөөрч, ямар нэг чиг хандлагад баригдах, хүлэгдэх албагүй гэж үздэг байна.

Идеалист хүн “хийсвэр” дүрэм журамд захирагдаж байдаг бөгөөд тодорхой нөхцөл байдалд л тохируулдаг, боломжтой бол тэр үедээ л болж байвал боллоо гэсэн хандлагаар аливаад ханддаггүй. Жишээлбэл дээрх өндөр хөгжилтэй орнуудад хүмүүс нь зам хөндлөн гарахдаа замын дүрмийг ямагт баримтлан, гэрлэн дохиог заавал дагадаг. Хэдийгээр замаар ганц ч машин яваагүй байлаа ч ногоон гэрэл асаагүй үед тэд зам хөндлөн гардаггүй, дүрэмдээ захирагдан хүлээж зогсдог. Харин хуучин марксист диалектик сэтгэлгээгээр хүмүүжүүлдэг байсан социалист орнуудад тухайлбал, манай Монголд болон Хятадад, мөн хуучин ЗХУ-ын уг, заавар, жишгээр байсан олон улс оронд хүмүүс замын дүрмийг үл тоох агаад гэрлэн дохиог ч анзаарахгүй, дуртай газраараа, дуртай үедээ зам хөндлөн гардгийг хэн хүнгүй л мэдэх билээ. Энэ бол сэтгэлгээний ялгаа.

Идеалист сэтгэлгээтэй улс орнуудын хүмүүс нийгэмд олон янзын үзэл бодол оршин байхыг хүлээн зөвшөөрч чаддаг бөгөөд өөр үзэл бодол, итгэл үнэмшлийг хүндэтгэдэг. Тэгэхдээ энэ нь заавал тэр зүйлийг дагадаг гэсэн үг биш, харин өөр үзэл бодол, итгэл үнэмшлийнх нь улмаас хүнийг зэмлэх шийтгэх, хохироон дарамтлах зэрэг зохисгүй байдлыг гаргадаггүй аж. Тэд ёс зүйг эрхэмлэж, хүний уг мөн чанар нь бүтээгч хүчит оюун ухаант сүнс буюу Бурханы мөн чанараас үүдэлтэй байдаг гэж үздэг учраас ерөнхийдөө хүнээ дээдэлж, тэднийг яс үндсээр нь ялгаварлан гадуурхаж, нутгархдаггүй. Тийм учраас л дээрх улс орнууд бусдаасаа илүү хөгжиж, ухаантай чадалтай олон хүнийг өөртөө татаж, тэдний мэдлэг чадварыг хөгжүүлэн ашиглаж, олон улсын харилцаанд голлох байр суурь, нөлөөтэй хэвээр байна.

Эртний их “Хөлгөн судар” хэмээгддэг, дэлхийн бараг бүх хэл, аялгуун дээр хөрвүүлэгдсэн гэж хэл шинжээчид, орчуулагчдын үздэг мөн хэвлэгддэг тоо ширхэгээрээ ч дэлхийд 1-рт ордог хамгийн бас сонирхолтой нь хамгийн олон удаа шатаагдаж, устгагдаж байсан Библи хэмээх номыг идеалистүүд гол үзэл баримтлалаа болгож Библээс олонтаа иш татсаар бүтээл, номлолдоо тусгасаар иржээ. Дэлхийн хүчирхэг гүрэн болох АНУ-ын ерөнхийлөгчид албан үүргээ хүлээж авахдаа уг номын дээр нь гараа тавин чин зүрхнээсээ тангараг өргөдөг цорын ганц ном болох тэрхүү Библи дээр *Бурхан анх орчлон хорвоо болон түүн дээр орших хүн төрөлхтөнийг бүтээсэн* гэж бичжээ. Хүнийг бүтээхдээ Бурхан өөрийнхөө мөн чанарыг шингээж, өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн гэж бичжээ. Библид бичсэнээр анхны хүн болох Адамаас хүн төрөлхтөн үүссэн учраас хүн төрөлхтөний хувь заяа нэг ажээ. Үүнээс улбаалан хэдийгээр хүмүүс олон өөр өөр улс гүрэнд хуваагдаж, ондоо ондоо яс үндэстэнд хуваагдан ялгагдаж, өөр өөр хэлээр ярьж харилцаж байгаа хэдий ч нийт хүн төрөлхтөний хувь заяа нэг гэдгийг идеалистүүд онцолдог. Тийм учраас нэг улсад болсон дайн бусаддаа нөлөөлж, нэг бүс нутаг, газар оронд болж буй гамшиг нийт дэлхий дахинд ноцтой нөлөөтэй байдаг нь аажимдаа даяаршил гэдэг зүйлийг авчирчээ. Бүх улс үндэстэн хүн ардууд өөр хоорондоо нэгэн биеийн олон өөр эрхтэн шиг л салшгүй холбоотой, салгашгүй нэгэн цул учраас тэр биз ээ.

Олон улсын харилцаа гэдэг нь үнэндээ хүн хоорондын харилцаа юм. Нэг л хувь заяатай, нэг нарны дор нэг дэлхий дээр амьдардаг хүн төрөлхтөнд олон туйлт ертөнц биш, харин нэг туйлт ертөнц буюу нэг л үзэл санаа байх нь ашиг тустай гэж идеалистүүд үздэг байна. Хүний санаагаар бол энэ нь хэзээ ч бүтэшгүй, бас дэмий зүйл мэт боловч харин идеалистүүд үзэхдээ: байгаль нийгмийг бүтээж, хүн төрөлхтөнийг үүсгэсэн тэр агуу хүчит санаа бодол – **идеа**, буюу оюун ухааны эх үндэс болох бүтээгч, оршин буй Бурханд хандан хүсвэл энэ нь боломжтой гэж итгэдэг байна. Хүний хүч, чадвар, мэдлэгээр бус харин Бурханы агуу хүч, хайраар дээрх зүйл боломжтой

ажээ. Чухам үүнд үндэслэн, олон улсын дэг журмыг тогтооход АНУ голлох ёстой гэсэн үзэл бий болоод байна. Яагаад заавал АНУ-г гэж? Магадгүй, хамгийн өргөн хүрээнд, хамгийн олон янзын өөр өөр үндэстэн ястнуудыг нэгэн дээвэр дор, нэг сэтгэлгээ нэг үзэл бодол дор нэгтгэж, тус тусынхаараа биш харин америкчууд гэсэн нэг нэрээр дуудуулдаг, эгэл жирийн хүний хүсэл хэрэгцээг ч харгалзан үздэг тийм нийгмийг цогцлоон босгож чадсан энэ улс нь дэлхий дээр бас тийм нийгмийг бий болгож чадна гэсэн итгэлээс дээрх үзэл санаа гарсан байж болох талтай.

Идеализмын онолын эх сурвалж болсон **Иммануэл Кантын “Улс түмний хооронд мөнхийн энх тайвныг цогцлон бүтээх тухай онол”** нь ч дээрх итгэл үнэмшилтэй холбоотой гэж үзэж болох юм. Түүний онолоор, орчлон хорвоо, хүн төрөлхтөнийг оргүй хоосноос бүтээсэн тэрхүү аугаа **идеа** буюу санаа бодол нь нийт хүн төрөлхтөнд болон олон улсын харилцаанд мөнхийн энх тайван, амар амгаланг авчирч чадах ажээ. Идеалистүүдтэй огт санаа нийлдэггүй реалистүүдийн хувьд энэ бол байж боломгүй тэнэглэл, хий хоосон зүйл. Марксист диалектик үзэлтэй, хуучин коммунист дэглэмтэй байсан улс орнуудын удирдагчдад дээрх үзэл тун инээдтэй сонсогддог байсан байж таарна. Тэгвч энд нэг сонирхолтой зүйл байна, юу гэвэл бүтээгч Бурхан байдаг гэдэгт огт итгэдэггүй хувь хүн олон боловч харин тийм ард түмэн, улс орон гэж байдаггүй. Бурхангүй үзэлтэн байдаг ч бурхангүй ард түмэн, улс орон гэж үгүй. Одоогийн үзлээр хүчний гол илэрхийлэл болсон мөнгө буюу америк доллар дээр *“Бид Бурханд итгэдэг” – “In GOD we trust”* гэсэн өгүүлбэр байдаг нь зүгээр л нэг санамсаргүй биччихсэн хэрэг биш бололтой.

Аливаа онолыг боловсруулагчид болон судлаачид нь хийсвэр эргэцүүлэлд биш харин бодитой баримтад тулгуурлах ёстой гэдэг боловч үнэндээ бидний эргэн тойронд буй амин чухал олон зүйлс тухайлбал: үг, хайр, урам зориг, найдвар, хүсэл, зорилго болон айдас, амар тайван байдал гэх мэт нь бодитой биш, нүдэнд харагдаж, чихэнд сонстож, гарт баригдахаар биш байдаг. Гэхдээ хүн итгэж найддаг, итгэлээр найдвараар амьдардаг. Тиймээс бодитой харагдаж буй ч цаг зуурынх байж болох аливаа улсын ашиг сонирхлыг эсвэл хүчний харьцааг бус, харин нийт хүн төрөлхтөний одоогоор харагдахгүй байгаа сайн сайхан ирээдүйг бодож аливаа шийдвэрийг гаргах нь олон улсын харилцаанд чухал нөлөөтэй байх болно гэж идеалистүүд үздэг байна.

Онолын судалгааны үүсэл

Олон улсын харилцааны онолын судалгаа нь олон улсын харилцаа болон улс төрийн шинжлэх ухааны судлагдахууны нэг билээ. Хүн төрөлхтөний түүхэнд анхны төрт улсууд үүсч, өөр хоорондоо харилцаж эхэлсэн үеэс олон улсын харилцаа төлөвшин тогтож, бусад улс гүрнүүдтэй яаж харилцвал ашигтай болох, яагаад харийн гүрнүүд халдан довтолж, эсвэл улс орон өөрөө бусадтай дайтаж байдгийн уг мөн чанарыг таньж мэдэх гэсэн үе үеийн түүхчид, их сэтгэгчдийн бодол эргэцүүлээс олон улсын харилцааны онолын судалгаа үүссэн гэдэг.

Яваа яваандаа улс хоорондын харилцаа нь олон улсын эрх зүйт хэв шинжтэй болж, тэр хэрээрээ улс гүрнүүдийн гадаад улс төрийн бодлого нь илүү далайцтай өргөн хүрээг хамран, төрийн түшмэдүүд гадаад бодлогын зорилго, зорилт, аливаа улс гүрний мөнхийн ашиг сонирхлын талаар сонирхон судлах болсноор, анхны суурь судалгааны зохиолууд бичигджээ. Тэгэхдээ тэд бүтээлээ олон улсын харилцааны онол гэж нэрлээгүй гэдэг юм.

Хүн төрөлхтний түүхэн дэх хоёр их дайны сургамж нь олон улсын харилцааны онол, онолын дэг, сургаалиудыг шинжлэх ухааны түвшинд хүрч төлөвшихөд нөлөөлжээ. Олон улсын харилцааны онолын дэг сургуулиуд нь дэлхийн улс орнуудыг их бага, өндөр хөгжилтэй, хөгжиж

байгаа, ядуу буурай гэж ялгалгүй хамарч байдаг, нэг улсын гадаад бодлого бусад улс орны ашиг сонирхлыг шууд хөндөж, хүсээгүй үр дагаварт хүргэх буюу эрх ашигт нь сөргөөр нөлөөлж болдог, олон улс хоорондын ярвигтай нарийн харилцаан дунд тухайн улс гадаад бодлогын зорилгоо хэрхэн хамгийн зөв, оновчтой тодорхойлж, мөнхийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх тухай зааж сургадаг бөгөөд олон улсын харилцаа нь түүхэн урт хугацаанд төлөвшиж явсаар XX зуунд л шинжлэх ухааны салбар болсон гэж үздэг. Олон улсын харилцааны түүх, олон улсын харилцааны талаарх шинжлэх ухаан нь Европ төвтэй учраас олон улсын харилцааны онолын дэг, сургуулиуд ч мөн Европт голлон хөгжжээ. Дэлхийн 1-р дайны дараа олон улсын харилцааны асуудлын талаар анх АНУ-ын их дээд сургуулиудад заах болсон бөгөөд өдгөө олон улсын харилцааны асуудлаарх судалгааны бүтээлийн ихэнх нь америкийн эрдэмтдийн бүтээл байна. Үүнд: Олон улсын харилцааны онолын шинжлэх ухаанд “Онолын эцэг” гэгддэг Х. Ж. Моргентау, Эдвард Х. Карр, мөн АНУ-ын Бурхны сургаалтан Нибүр нарыг нэрлэх ёстой. Мөн францын нэрт эрдэмтэн Р. Арон, оросын П. А. Цыганков, америкийн И. Валлерстайн, К. Уолц зэрэг олон эрдэмтэн, судлаачдын бүтээлийг дурдаж болно.

“Хүйтэн дайн” төгсгөл болсноор олон улсын харилцааны орчин огцом өөрчлөгдөж чанарын өөрчлөлтөд шилжсэн билээ. Олон улсын тавцанд тусгаар улсуудыг болон шинээр гарч ирсэн оролцогчдыг хүлээн зөвшөөрч эхэлсэн бөгөөд өдгөө улс хоорондын харилцаа нь даяаршил, интеграцийн нөлөөгөөр улам ойртон нягтарч, улс орнууд нэг нэгнээсээ шууд хамаарах болоод байна.

Манай улс олон улсын харилцаанд бие даан оролцох болсоноос үзэл сурталжсан хуучин гадаад бодлогоосоо татгалзаж, нээлттэй, олон тулгуурт бодлого баримтлах болсон билээ. Монгол жижиг улс тул ашиг сонирхлоо зөв тодорхойлж, гүйцэлдүүлэхийн тулд баримтлах онолын үзэл баримтлалаа зөв сонгох шаардлагатай байна. Орчин цагийн олон улсын харилцааг тайлбарлах, ОУХ-ы онолын үзэл хандлагыг системтэй судлах, Монгол улсын хэмжээнд эрдэм шинжилгээний түвшинд орчин цагийн олон улсын харилцааны онолын үзэл хандлага, баримтлалуудыг нэгтгэн нэр томъёог цэгцэлж, үр дүнг нь мэргэжлийн сургалттай их дээд сургуулиудын хүрээнд баримтлах зэрэг олон асуудал тулгамдсан хэвээр байна гэж мэргэжлийн олон улсын харилцааны ажилтнууд, дипломатууд, эрдэмтэн багш нар үзэж байна. Миний бодлоор, Монгол улсын хувьд олон улсын харилцааны онолын судалгаа ядмаг байгаа энэ үед дээрх эрдэмтэд судлаачдын зохиол бүтээлийг мэргэжлийн чадварлаг багш судлаачид маань орчуулж, сургалт эрдэм шинжилгээний ажилдаа тусган хэрэглэх нь чухал хэрэгтэй, өгөөжтэй ажил болж болох буй за.

Олон улсын харилцааг улс төрийн шинжлэх ухаанд багтаан оруулж байдаг үндсэн холбоос нь олон улсын харилцааны онол. Улс төрийн шинжлэх ухаан дотор олон улсын харилцааг судлах нь нэн ярвигтай гэх юм. Учир нь олон улсын харилцаа гэдэг нь өөрөө богино хугацаанд хувьсч өөрчлөгдөж байдаг, тогтворгүй судлагдахууны нэг аж. Хэдий тийм боловч ОУХ нь улс төрийн бусад системийн нэгэн адил өөрийн зүй тогтлоор оршин тогтнож, хөгжин дэвжиж байдаг бөгөөд энэхүү зүй тогтлыг нь зөв таньснаар аливаа улс орон мөнхийн ашиг сонирхлоо хамгаалж, мөн түүний илрэл болсон гадаад бодлогоо амжилттай хэрэгжүүлж чадах билээ.

Ийм учраас олон улсын харилцааны түүх болон ОУХ-ы онолын харилцан хамаарлыг тодорхой тогтолцоонд оруулан судлах шаардлагатай байна.

Онолын дэг сургуулиуд

Олон улсын харилцааны үндсэн асуудал болох ОУХ-ы онолын талаар дорвитой томоохон ажлуудыг хийж гүйцэтгэн, бие даасан онолын сургуулиудыг үүсгэж чадсан эрдэмтэд нь АНУ-ын эрдэмтэд ажээ. Онолын дэг сургуулиудыг судлахын тулд улс орнуудын хоорондын харилцааны мөн чанар, зүй тогтлын талаар анхлан судалгаа хийж, ОУХ-ы шинжлэх ухааныг үндэслэсэн Спайкмэн, ОУХ-ы онолыг шинжлэх ухааны түвшинд гаргасан Х. Моргентау нарын судалгаа, зохиол бүтээлийг уншиж судлах ёстой. Англи, Франц, Германы эрдэмтдийн зохиол бүтээлийг ч мөн чухалчлан авч үзэх хэрэгтэй нь мэдээж. 1960-аад онд социологийн болон улс төрийн социологийн шинжлэх ухаан эрчимтэй хөгжиж байх үед Р. Арон, К. Уолц, Т. Парсонс зэрэг эрдэмтэд үр дүнтэй судалгаа хийж, бүтээллүүддээ үнэтэй саналуудыг дэвшүүлжээ.

Дэлхий дээр олон жилийн турш хоёр туйлт тогтолцоо оршин байх үед Орос улс нь дэлхийн социалист эвсэлд багтаж байсан бусад улсуудын нэгэн адил ОУХ-ы онолын асуудалд ангийн шалгуураар хандаж байсан бөгөөд түүний хувьд ОУХ-г судлах цорын ганц хүлээн зөвшөөрөгдсөн онол нь улс төрийн марксизм байлаа.

1990-иэд оноос ОУХ-д гарсан хурдтай өөрчлөлт, дэлхийн хөгжлийн чиг хандлага, зүй тогтолд нэгэн зэрэг гарсан хувьслууд нь олон улсын харилцааны уламжлалт онолын үзэл баримтлалуудыг эргэн харахад хүргэж, шинэ үзэл баримтлал, шинэ хандлагуудыг олноор нь төрүүлжээ. Үүнтэй холбоотой олон тооны судалгааны өгүүлэл, бүтээлүүд гарчээ. Жишээлбэл, С. Хантингтоны “Соёл иргэншлийн мөргөлдөөн”, Фукуямагийн “Түүхийн төгсгөл”, Валлерстайны “Дэлхийн шинэ тогтолцооны мөн чанар” зэрэг бүтээлүүдэд онолын сонирхолтой саналуудыг дэвшүүлж, ОУХ-ы онолын асуудлуудыг нэгтгэх, шинэчлэх шаардлагатай байгааг нотлон харуулж чаджээ.

“Олон улсын харилцаа” хэмээх нэр томъёог 1919 онд Их Британий эрдэмтэн анх хэрэглэсэнээс хойш олон улсын харилцаа нь улс хоорондын харилцаа, тэр дундаа улс хоорондын эрх зүйт улс төрийн харилцааны талаарх судалгаа болж шинжлэх ухааны түвшинд хүрч хөгжжээ. Дэлхийн 1-р дайны дараа АНУ ба Их Британид, Дэлхийн 2-р дайны дараа Францад олон улсын харилцаа нь богино хугацаанд улс төрийн шинжлэх ухаанаас салж, шинжлэх ухааны бие даасан салбар болтлоо үсрэнгүй хөгжиж чаджээ. Ийнхүү олон улсын харилцааг биеэ даасан шинжлэх ухаан болоход дээр нэр дурдсан хэд хэдэн эрдэмтдийн судалгаа, бүтээлүүд голлох ач холбогдолтой үүргийг гүйцэтгэсэн гэж үзлэг.

АНУ-ын эрдэмтэн Ханс Моргентаугийн 1948 онд гаргасан “Politics among Nations: The Struggle for Power and Peace” буюу “Үндэстэн хоорондын улс төрийн харилцаа: Засаглал ба Энх тайвны төлөөх тэмцэл” нэртэй зохиолыг олон улсын харилцааны онолын анхдагч томоохон, үндсэн бүтээл болсон гэж үздэг. Тэрээр уг зохиолоороо дамжуулан ОУХ-ы мөн чанарыг гаргахыг эрмэлзсэн бөгөөд судалгааныхаа үр дүнд үндэсний ашиг сонирхлын онол /концепци/-ийг гаргажээ. Дараа нь францын эрдэмтэн Р.Ароны улс төрийн социологийн дорвитой судалгааны үр дүнд туурвигдсан “Үндэстэн хоорондын дайн ба энх” хэмээх бүтээл олон улсын харилцаанд улс төрийн социологи нэртэй шинэ салбарыг үндэслээд зогсоогүй, олон улсын харилцааны онолын уламжлалт хандлагуудыг эвджээ. Олон улсын харилцааны зүй тогтол өөрчлөгдөж, ОУХ-ы оролцогчид төдийгүй орчин нь шинэ болж эхэлснийг онцолсноор А. Розенау нь ОУХ-ы онолын бүтцийн онолыг гаргажээ. Түүний бүтээлүүдэд олон улсын харилцааны мөн чанар нь тухайн системийнхээ бүцтэд оршдог гэсэн санаа голлож байдаг.

Аливаа онол нь судлах объектийнхоо онцлогийг гаргаж, бүтэц бүрэлдэхүүнийг нь тайлбарлах, цаашдын хөгжлийн чиг хандлагыг нь урьдчилан дүгнэх гэсэн үндсэн хоёр үүргийг гүйцэтгэдэг билээ. Бусад шинжлэх ухааны нэгэн адил олон улсын харилцааны онол нь өөрийн судлах зүйл, судалгааны объект, үндсэн ухагдахуун буюу категориудтай байдаг. Товчоор хэлбэл, ОУХ-ы онол нь улс хоорондын олон талт нийгмийн харилцаанаас улс төрийн харилцаанд гол ач холбогдлыг өгөн судалдаг онол юм. Ингэхдээ, албан ёсны буюу улс хоорондын, засгийн газар хоорондын олон талт харилцааг судлах бөгөөд энэхүү харилцаа нь гадаад бодлогоор уялдаж байдаг аж. Эрт цагаас эхлэн улс орнууд өөрийнхөө хөгжилт цэцэглэлтийг дэмжин хангах, хөрш болон бусад улс орнуудтай харилцахдаа өөрт ашигтай тэр л харилцааг хөгжүүлэхийг эрмэлзсээр ирсэн түүхтэй. Ийнхүү, олон улсын харилцааны онолын анхны үндэслэлийг хөгжүүлэх шаардлага тавигджээ.

XV зуунд Италийн их сэтгэгч Макиавелли “Ноён” нэртэй номоо хэвлүүлснээр улс орны мөнхийн ашиг сонирхол гэж юу болохыг өгүүлж, түүнийг хангах, гүйцэлдүүлэхийн тулд чухам ямар арга, бодлого боловсруулан баримтлах ёстойг заажээ. 1648 онд 30 жилийн дайныг төгсгөл болгож Вестфалийн олон улсын гэрээнд Европын улсууд нэгдсэн бөгөөд ийнхүү тусгаар улс хоорондын анхны олон улсын эрх зүйт харилцааг үндэслэснээр үндэсний гадаад бодлогыг идэвхтэй болгох, улсын ашиг сонирхлыг зөв тодорхойлох зэрэг олон улсын харилцааг хөгжүүлэх онолын зүй ёсны шаардлагууд гарч иржээ.

Дэлхийн 2 их дайны үр дагавраар ОУХ-ы онолын шинжлэх ухаан үндэслэгдсэн гэдэг. Дэлхийн 1-р дайны дараа Их Британий Уэльсийн Эйберевистийн их сургуульд олон улсын харилцааны анхны тэнхмийг байгуулж, тус тэнхмийн хүрээнд олон улсын харилцааны асуудлаар судалгаа хийх болсноор Олон улсын харилцааны онолын шинжлэх ухааны суурь тавигдсан гэж үздэг. “Хүйтэн дайн”-ы нөлөөгөөр сөргөлдөгч, дайсан улсын ашиг сонирхлыг хэрхэн урьдчилан таах, мөн гадаад бодлогын хариу тактикийг яаж зөв боловсруулах зэрэгт онол чухал нөлөөтэй байлаа. 1990-иэд оноос олон улсын харилцааны хоёр туйлт тогтолцоо задран унаснаар онолын шинэ эрэл хайгуул, маргаан дэгдсээр өнөөг хүрэв. Олон үзэл бодлын хооронд уламжлалт маргаан ч дэгдсээр байна. Энэ нь олон улсын харилцааны онолын хөгжилд эерэгээр нөлөөлсөн гэж үздэг эрдэмтэд ч бий. Олон улсын харилцааны түүхээс ажиглахад олон улсын харилцаанд үйлчилж байсан нэг тогтолцоо задран унаж, улмаар хямарч эхлэхэд олон улсын харилцааны онолын шинэ эрэл хайгуул бий болж, маргаан шүүмж дэгддэг байна.

Олон улсын харилцаа нь хамтын ажиллагаа ба дайсангал гэсэн хоёр зүй тогтлоор хөгжиж байдаг. Олон улсын харилцааны онолын объект нь улс хоорондын улс төрийн харилцаа, тэдний гадаад бодлого байдаг. Улс төрийн харилцааг нь тусгаар улсын ашиг сонирхол, үйл ажиллагааны хүрээ гэж өргөн утгаар авч үздэг бөгөөд явцуу утгаараа засгийн эрх баригчдын хоорондын харилцаа байдаг. Олон улсын харилцааны онолын судлагдахуун буюу предмет нь бусад шинжлэх ухааны нэгэн адил хувьсч болох ч өнөөгийн байдлаар олон улсын харилцаа байсаар байна. Тэгэхээр ОУХ-ы онолын үндсэн ойлголт нь олон улсын харилцаа өөрөө юм.

Олон улсын харилцааг эрдэмтэд, судлаачид янз янзаар тайлбарладаг. Чухам хэн ямар шалгуураар яаж тодорхойлсноос хамааран онол нь харилцан адилгүй байсаар иржээ. Олон улсын харилцаа, дэлхийн бодлого, гадаад бодлого, гадаад дотоод бодлогын холбоо хамаарал нь ОУХ-ы онолын үндсэн судлагдахуун, ойлголт байсаар ирсэн бөгөөд тэдгээр ойлголтыг яаж тайлбарлаж, ямар арга аргачлалаар судалж байгаагаас хамааран олон улсын харилцааны бие даасан хэд хэдэн

онолын урсгалууд бий болон хөгжжээ. Үүнд улс төрийн реализм, шинэ реализм, улс төрийн **идеализм**, марксизм, шинэ марксизм, транснационализм, шинэ либерализм, дагуул улсын онол, бүтцийн онол, үндэстэн дамнах онол зэргийг дурдаж болно.

Онолын үндсэн хандлага болох реалист, **идеалист**, марксист урсгалуудыг уламжлалт урсгалд тооцдог. Орчин цагт ОУХ-ы мөн чанар өөрчлөгдөхийн хэрээр эдгээр урсгалын хооронд, мөн шинээр үүссэн транснационалист, глобалист урсгалуудын хооронд онолын шинэ маргаан үе үе дэгддэг. Учир нь эрдэмтэд олон улсын харилцааны мөн чанарыг тайлбарлахдаа онолын өөр өөр өнцгөөс ханддаг ажээ. ОУХ-ы онол, урсгал, чиглэлүүдийн маргааны гол сэдэв нь олон улсын харилцааны мөн чанар, шинж чанар юм.

Улс төрийн идеализм болон идеалистүүдийн итгэл үнэмшил

Идеалистүүдын ерөнхий итгэл үнэмшил болон үзэл хандлагын талаар дээр өгүүлсэн билээ. Харин энэ хэсэгт идеализмыг онолын талаас нь авч үзье.

Идеалистүүдийн үзлээр олон улсын харилцааны цорын ганц субъект нь улс орнууд биш ажээ. Өөрөөр хэлбэл улс орнууд нь олон улсын харилцаанд голлох этгээдүүд биш гэж тэд үздэг. Олон улсын харилцааны гол үүргийг олон улсын байгууллагууд болон засгийн газар хоорондын байгууллагууд гүйцэтгэх ёстой гэдэг байна.

Идеалистүүдийн үзэж буйгаар онол үйлдлэгийн үндсэн гол асуудал нь:

1. Даяарыг хамарсан хүн төрөлхтөний нийтлэг эрх ашиг, эрхэмлэх зүйл, туйлын зорилго зорилт
2. Хүн хэмээх бодгалийн хасашгүй эрхийг хамгаалж хэрэгжүүлэх явдал
3. Бүхнийг хамарсан аюулгүй байдлын тогтолцоог бий болгон хамгаалах зэрэг нь юм гэж үздэг.

Реалистүүд бол хүчээр (энэ нь мөнгө буюу цэргийн хүчин чадал, эдийн засгийн өндөр чадавхийг хэлж буй хэрэг), харин **идеалистүүд нь яриа хэлэлцээ болон хамтын ажиллагаагаар дамжуулан олон улсын харилцаан дахь аливаа зөрчлийг шийдвэрлэж болно гэж үздэг.** Идеалистүүд хувь хүний эрх ашгийг хамгаалж, үүний төлөө буй болгосон дүрэм журмаар олон улсын харилцааны шинэ журмыг бий болгож болно гэж баталдаг. Тэд Дэлхий дахины Зохирол - World Harmony буюу Бүх Нийтээр Эвтэй найрсагаар зохицон амьдрах тийм амьдралыг бий болгож болно гэсэн Бурханлаг үзэл санаатай бөгөөд хүн төрөлхтөний нийтлэг ёс суртахууныг бий болгож болно гэж үзэж итгэдэг байна.

Өнөө үед олон судлаачид олон улсын харилцааны онолын талаар ярихдаа *идеализм* хэмээх нэр томъёог хэрэглэхээс зайлсхийх болжээ. Учир нь идеалистүүдийн дунд улс төрийн реализмын үндэслэлийг үгүйсгэх хандлага их гарах болсон аж.

Германы сонгодог философийн гол төлөөлөгчид болох Кант, Фихти, Шилинг, Гегель нар нь идеалист үзэлтнүүд байсныг дээр дурьдсан билээ. И. Кант “Улс түмний хооронд мөнхийн энх тайвныг цогцлон бүтээх” тухай онол дэвшүүлсэн нь идеализмын онолын эх сурвалж болсон гэж үздэг. Мөн түүнчлэн Гегелийн үзэж байснаар **идеа** буюу үзэл санаа нь материаллаг ертөнц ба оюун ухааны үзэгдэлүүдэд харшлахгүйгээр үл барам тэдгээрт хувилан агуулагдаж, тэдгээрээр дамжин мөн чанараа илэрхийлж байдаг байна. Ертөнцийн үзэл санаа нь байгаль, нийгмийн илэрч болох бололцоотой бүхий л үзэгдлүүдийг өөртөө нууцлан агуулж, тэдгээрийн эх үүсвэр,

хөдөлгөх хүч болж мөнхөд оршиж байдаг гэж Гегель сургаж байжээ. Түүний үзлээр бол үзэл санаа нь хөгжлийнхөө явцад хэд хэдэн шатыг дамжиж, додоод агуулгаа улам бүр бүрэн дүүрэн нээн гаргадаг байна. Туйлын үзэл санаа нь эхлээд өөрөө өөртөө хөгжиж байснаа дараа нь амьгүй ба амьд байгалийн хэлбэр, хүний хэлбэрийг тус тус олж улмаар төр, урлаг, шашин, философийн хэлбэртэй болон илэрдэг байна. Ингэж ертөнцийн янз бүрийн үзэгдэл нь цөм гагцхүү бүтээлч хүч болох үзэл санааны өөрийн нь хөгжлийн бүтээгдэхүүн болдог. Ийнхүү үзэл санаа буюу идеа нь анхдагч, харин материаллаг ертөнц бол хоёрдогч гэж үздэг Гегелийн сургаал нь ертөнцийг Бурхан бүтээсэн хэмээх баталгааг философийн өвөрмөц хэллэгээр илэрхийлэн илтгэж байгаа хэрэг болдог байна.



Улс төрийн идеализмын онолын гол дүгнэлт нь:

Энэхүү онолыг баримтлан хэрэгжүүлснээр:

1. Олон улсын харилцааг ардчилаж, бүх нийтэд тохирсон эрх зүйн зохицуулалт хийнэ. Мөн ёс суртахуун, шударга ёсны хэм хэмжээг бий болгон нэвтрүүлснээр аливаа дайн дажин, мөргөлдөөнийг зайлуулж болно.
2. Дайсагнахыг завдсан буюу дайсагнагч тал нь ардчилсан улс орнуудаас бүрдсэн дэлхийн хамтын нийгэмлэгийн болон олон нийтийн зүгээс үзүүлэх дарамт шахалт, мөн дэмжлэгийн тусламжтайгаар сайн дураараа зэвсгээ хураалгана.
3. Дайн бол олон улсын харилцааны бодлогын хэрэгсэл биш гэж харилцан хүлээн зөвшөөрснөөр дэлхийн хамтын нийгэмлэгийг байгуулж болно гэж идеалистүүд үзэж байжээ.

НҮБ байгуулагдсанаас хойш дэлхийг хамарсан том хэмжээний дайн гараагүй нь идеалист үзэл бодлын бас нэгэн үр нөлөө гэж үздэг эрдэмтэд олон байдаг аж.

Идеализмын онолыг баримтлагч нэрт хүмүүсийн заримаас нь дурьдвал Францын Ст. Саймон, Английн Ричард Гобден ба Бертранд Рассел, АНУ-ын Вүүдро Вильсон ба Франклин Д. Рузвельт, Энэтхэгийн Махатма Ганди болон Нерү нар мөн орох болно.

ДҮГНЭЛТ

Олон улсын харилцааны онол болон улс төрийн шинжлэх ухааны судлах гол зүйл нь хүний нийгэм. Тэгэхээр хүний нийгмийг судлахын тулд хүнийг л судлах хэрэгтэй гэсэн үг. Хүний мөн чанар ямар болохыг, хүмүүс хичнээн их муу муухайг үйлдээд, төлөвлөөд, бодоод байдгийг биш, харин хүн ямар байх ёстойг, эцэстээ юу нь чухал болохыг, явал муугаас илүү зөв сайныг үйлддэг, боддог болгох боломж арга замыг судалж мэдээд, хүн төрөлхтөнд хэлж өгч, зааж, чиглүүлэх нь эрдэмтэн мэргэд, багш судлаачдын үүрэг гэж бодож байна. Онол практикаар шалгагддаг гэдэг. ОУХ-ы онолын нэг болох улс төрийн идеализмын онол нь эрт үеэс шалгагдсаар тэсч үлдээд, техник технологи өндөр хөгжсөн эдүгээ цагт ч хүчтэй онолын нэг хэвээр байна.

Идеа - хүчит санаа бодол буюу оюун ухааныг таньж мэдэхийн тулд хүн төрөлхтөн янз бүрийн арга хэрэглэсээр, төрөл бүрийн шашин, үзэл онолыг боловсруулан зохиосоор, сүүлдээ зохиосон зүйлдээ итгэж баримталсаар иржээ. Үнэхээр тийм санаа, *бүтээгч санаа* анх оршин байж, тэр нь байгаль, нийгэм болон түүн дээр оршигч улс орнууд, хүн төрөлхтөнийг бий болгосон гэж эрт үеэс олон эрдэмтэн мэргэд итгэсээр ирсэн учраас идеализм буюу оюун санаа анхдагч гэсэн энэ үзэл олон мянган жил байсаар, эрдэмтдийн үг яриа, зохиол бүтээлээс хасагдалгүй явсаар өнөөгийн бидэнд өвлөгдөн хүрч иржээ.

Тэгэхээр, олон улсын харилцааны онолыг судалдаг, өөрөөр хэлбэл улс орнуудын өөр хоорондын харилцан хамаарал, тэдгээрийн дэлхий дахинд үзүүлэх нөлөөллийг судалж; энх тайван, сайн сайхныг цогцлоон бүтээхийг эрмэлзэн тэмүүлсээр ирсэн хүн төрөлхтөний гэгээн үйлст хувь нэмрээ оруулахыг хүсч буй хэн бүхэн, засгийн газар, олон улсын байгууллага, хувь хүн хэн ч бай, хамгийн тохиромжтой зөв аргыг сонгохын тулд ихийг судалж, их уншиж, эрдэмтэн мэргэдийн үг сургаалыг анхааралтай авч үзэх, аливаад зөвхөн толгойгоороо бус бас зүрх сэтгэл, итгэл найдвар, зөв санаа бодлоор хандах нь маш чухал гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. “International Relations and Politics” (Theoretical Perspective in the Post-Cold War Era); J.C. Johari., 2009
2. Д. Дагвадорж “Гүн ухаан”
3. Р. Нансал “Философийн шилдэг төлөөлөгчид”